

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Монгол Улсад тариалангийн индексжүүлсэн даатгал нэвтрүүлэх боломж



Герман – Монголын хамтын ажиллагааны
“Тогтвортой хөдөө Аж ахуй” төсөл

Себастиан Маалер
2018 оны 11-р сар



**Герман – Монголын хамтын
ажиллагааны Тогтвортой хөдөө Аж
ахуй төсөл**

Монгол Улсад тариалангийн индексжүүлсэн даатгал нэвтрүүлэх боломж



ГАРЧИГ

1. ҮНДЭСЛЭЛ.....	1
2. ДААТГАЛЫН СИСТЕМ: УЛАМЖЛАЛТ БА ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ...3	
Уламжлалт даатгал.....	3
Индексжүүлсэн даатгал.....	4
Уламжлалт болон индексжүүлсэн даатгалыг харьцуулах нь.....	6
3. ТООН МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	7
ХААДД ХК-аас санал болгож буй даатгалын бүтээгдэхүүн.....	7
Даатгуулсан таримал/ талбай.....	8
Үндсэн эрсдэлүүд болон цаг агааны мэдээний дүн шинжилгээ.....	9
Даатгалын хураамжийн өсөлт.....	14
Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ.....	15
Зардлын хувь хэмжээ.....	17
Ургацын хэмжээ.....	17
4. ТӨРИЙН ДЭМЖЛЭГ – БОЛОМЖ БА ХЯЗГААР.....	21
Тариалангийн даатгал дахь Төрийн татаас, урамшууллын тогтолцоо....	22
5. БОЛОМЖИТ ХУВИЛБАРУУДЫН ШИНЖИЛГЭЭ.....	24
6. СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ОРУУЛСАН НЭМЭЛТҮҮД.....	28
7. ЭХ СУРВАЛЖ.....	30

1.Үндэслэл

Монгол Улс нь Төв Азийн зүүн хэсэгт байрлах бөгөөд нийт газар нутгийн 1/3 хэсгийг уулархаг нутаг эзэлдэг.

Газар зүйн байршил, байгаль цаг уурын онцлогоос шалтгаалаад Монгол орны газар тариалгийн үйлдвэрлэл нь эдийн засгийн өндөр эрсдэл бүхий салбар юм.

Монгол орны эрс тэс уур амьсгалд олон төрөл зүйлийн таримал ургамлыг тариалах боломжгүй байдаг бөгөөд тариалан эрхлэх боломжтой нийт талбайн багахан хувь нь газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдаж байна. Монгол улсын хөдөө аж ахуйн салбарт уламжлалт мал аж ахуй нь голлох байр суурийг эзэлдэг. Тариалангийн салбарын хувьд улаан буудай, арвай, овъёос болон төмсийг голчлон тариалдаг ба харьцангуй бага талбайд эрдэнэ шиш, бог будаа, рапс тариалж байна.

Хөдөө аж ахуйн нь монголын эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг ба дотоодын нийт бүтээгдэхүүний 14%-ийг эзэллэж байна. Төрөөс газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор авч хэрэгжүүлсэн олон арван төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд 2016 онд нийт 1490 тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүд бүртгэгдсэн ба жилд дунджаар 300.000-350.000 га талбайд улаан буудайн тариалалт хийж байна.

Тариаланчдын хувьд улаан буудай нь эдийн засгийн өндөр ач холбогдолтой таримал бөгөөд га-гаас дунджаар 16,7 центнер ургац авч байна. Тариалангийн аж ахуйн нэгжүүд дунджаар 100-30.000 га талбайд тариалалт хийдэг бөгөөд энэ нь нэг аж ахуйн нэгжид дунджаар 800 орчим га талбай ноогддог гэж ойлгож болно. Тус салбарт 3000 га ба түүнээс дээш эргэлтийн талбайтай 20 орчим томоохон аж ахуйн нэгж, компаниуд үйл ажиллагаа явуулж байна.

2015 онд Монгол орны газар тариалангийн бүс нутгуудын дийлэнх нь гантай байсны улмаас ОХУ-аас нийт 7,8 тэрбум төгрөгийн үнэ бүхий үр импортлон оруулж иржээ.

Монгол Улсын Засгийн газраас 2010-2016 оны хооронд тариаланчдад нийт 108,8 тэрбум төгрөгийн татаас олгосон ба энэ нь жилд дунджаар 15,5 тэрбум төгрөгтэй тэнцэх юм. Энэхүү татаасыг тариаланчдад хаврын тариалалтад зориулж шатахуун, үрийн буудай зэргийг худалдан авахад урамшуулал хэлбэрээр олгосон байна. Сүүлийн жилүүдэд Төрөөс

тариалангийн салбарт авч хэрэгжүүлж буй бодлого болон улсын төсвөөс шалтгаалан тариаланчдад олгох урамшууллын хэлбэр, хэмжээнд мөн өөрчлөлт орж байна. Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас (ТЭДС) дараах урамшуулал, дэмжлэгүүдийг үзүүлж байна. Үүнд:

Үндсэн дэмжлэг	Урьдчилгаа төлбөр	Бусад дэмжлэг	Урьдчилгаа төлбөр
Үрийн буудай	40 %	Трактор	20 %
Шатахуун	50 %	Дагалдах техник	20 %
Ургамал хамгааллын бодис	30 %	Жимс жимсгэний техник	30 %
Бордоо	30 %	Төмс болон хүнсний ногооны техник	20 %

ТЭДС-аас тариаланчдад зориулан хаврын тариалалтын үеэр үрийн буудай, шатахуун, ургамал хамгааллын бодис болон бордоо худалдаж авахад нь дэмждэг. Ингэхдээ тариаланч тодорхой хувийн урьдчилгаа төлж авах ба үлдэгдэл төлбөрийг намрын ургац хураалтын дараа үрийн буудай эсвэл мөнгөн хэлбэрээр эргүүлэн төлдөг. Мөн ТЭДС-аас улаан буудайн урамшуулалд жилд дунджаар 10 орчим тэрбум төгрөгийг буудай үйлдвэрлэгч иргэд, аж ахуй нэгжүүдэд олгодог. Төрөөс үзүүлж буй энэхүү дэмжлэг нь буудайн дотоодын хэрэгцээг бүрэн хангахад чиглэгддэг болно.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК (ХААДД ХК) нь Монгол Улсад тариалангийн даатгалыг нэвтрүүлэх, хөгжүүлэх ажлыг хариуцан ажиллаж байна. ХААДД ХК-ийн тариалангийн даатгалд анх (нэрлэсэн эрсдэлийн даатгал) улаан буудай тариалдаг нэг аж ахуйн нэгж хамрагдаж байсан бол 2017 онд энэ тоо нь 10 болж өсчээ. Тариалангийн салбар нь эрсдэл ихтэй учир даатгалын хураамж нь өндөр байдаг ба харамсалтай нь ихэнх тариаланчид өнөөдөр өндөр үнэтэй даатгалын бүтээгдэхүүн худалдаж авахад бэлэн биш байна. Мөн тариаланчдын багагүй хэсэг нь банкны зээлтэй байдаг бөгөөд байгалийн болон гэнэтийн давагдашгүй хүчин зүйл тохиож, хохирол учрахад ихэвчлэн Төрийн дэмжлэг, тусламжаас хараат болдог. Иймд Монголын тал Төрийн татаас, дэмжлэгийг оновчтой ашигласан, техник эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тариалангийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэхээр зорьж байна.

Энэхүү ТЭЗҮ нь Монголын тариалангийн салбарын онцлогт тохирсон даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэхэд санхүүгийн болон системийн боломжийг үнэлэхэд чиглэгдэнэ.

2. Даатгалын систем: Уламжлалт ба индексжүүлсэн даатгал

Уламжлалт даатгал

Уламжлалт даатгал нь даатгалын үндсэн хоёр хэлбэрийн нэг бөгөөд даатгагч нь даатгалын тохиолдол гарсан үед учирсан нийт хохирлоос даатгалын нөхөн олговрыг тооцож даатгуулагчид төлдөг. Энэхүү даатгалын хэлбэр нь нөхөн олговрыг учирсан хохирлоос хамааран олгодгоороо бодит хэрэгцээг нөхөх зарчмыг бий болгодог. Даатгалын хохирол үнэлэгч нь даатгуулагчийн мэдээлэл эсвэл хөндлөнгийн мэргэжилтний гаргасан үнэлгээнд тулгуурлан нөхөн олговрын хэмжээг тогтооно. Ихэнх улсад даатгалын нөхөн олговор учирсан хохирлоос их байхыг хориглодог. (ХБНГУ-ын Даатгалын тухай хууль § 74).

Зах зээл дээр уламжлалт даатгалын олон төрөл, хэлбэрүүд байдаг. Тухайлбал:

- Хязгааргүй ашиг сонирхлын даатгал,
- Анхны эрсдэлийн даатгал,
- Бүрэн үнэлгээний даатгал,
- Хагас үнэлгээний даатгал,
- Өөрийн хүлээх хариуцлагатай даатгал г.м.

Уламжлалт даатгалын нөхөн олговор нь учирсан хохирлын хэмжээ, даатгалын үнэлгээ, даатгалын үнэ гэсэн 3 түвшингээр хязгаарлагддаг.

Иймд даатгалын үнэлгээ нь даатгалын тохиолдолд нөхөн олговрын дээд хязгаар болох ба ихэнхдээ даатгалын хураамжийг тооцоолоход суурь дүн болдог. Уламжлалт даатгал хэвийн ажиллах гол нөхцөл нь хохирлыг үнэлэх үнэлэмжтэй (үнэлэмж нь тухайлбал: цагийн үнэлэмж, шинээр худалдан авах үнэлэмж, засвар үйлчилгээний үнэ г.м.) байх явдал юм.

Уламжлалт даатгалын үндсэн хоёр хэлбэр байдаг ба нэгд ургацыг батлан даах даатгал (Америк улсын Multiple Peril Crop даатгал болон Испани улсын ургацын даатгал) болон ургацын алдагдлыг нөхөх даатгал (Герман болон Австри улсад хэрэгждэг мөндрийн даатгал) юм.

Ургацыг батлан даах даатгалд ургацын дундаж хэмжээг /Strike Level/ зайлшгүй тогтоох шаардлагатай ба тухайн жилийн ургац нь гэрээнд заасан хэмжээнд хүрээгүй тохиолдолд нөхөн олговрыг олгодог. Даатгуулагч аж ахуйн нэгжийн ургацын дундаж хэмжээг /Strike Level/ тогтоохдоо тухайн аж ахуйн нэгжийн сүүлийн жилүүдийн дундаж ургац, эсвэл тухайн нутаг орны ургацын дунджаар тогтоодог. Аж ахуйн нэгжийн ургацын дундаж нь, тухайн нутаг орон/ бүс нутгийн дундажтай аль болох харилцах хамааралтай байх нь чухал.

Харин ургацын алдагдлыг нөхөх даатгал нь даатгалын нөхөн олговрыг тарималд учирсан бодит хохирлоос тооцдог. Энэхүү даатгалын гол зарчим нь учирч болох эрсдэлийг даатгалын гэрээнд тодорхой тусгасан байх ба зөвхөн гэрээнд тусгасан эрсдэлүүд үүссэн тохиолдолд нөхөн төлбөрийг олгоно. Хохирлын хэмжээг тооцохдоо хохирол учраагүй тохиолдолд олох байсан орлогын хэмжээг суурь дүн болгон ашиглана. Ургацын алдагдлыг нөхөх даатгалд даатгалын үнэлгээг ихэвчлэн тогтсон тарифаар тооцох ба тухайн нөхцөл байдлаас шалтгаалан тарифт өөрчлөлт оруулж болно. Даатгалын хураамжийг тооцохдоо өмнөх жилүүдийн мэдээлэл, эрсдэл тохиох магадлал болон даатгуулагчийн сонгосон даатгалын үнэлгээг харгалзан үздэг. Даатгалын нөхөн олговрыг даатгалын үнэлгээний хэдэн хувиар тооцохыг гэрээнд тодорхой тусгана. Даатгалын тохиолдол гарсан үед даатгалын шинжээч хохирлын үнэлгээ хийх ба тухайн хохирлын протоколыг үндэслэн даатгалын компани нь нийт хохирлыг нөхөн олгох эсвэл цаашид хохирлын түвшнийг хэлэлцэх шаардлагатай эсэх талаар шийдвэр гаргана.

Энэ төрлийн даатгалын гэрээг эрсдэл тус бүр дээр эсвэл өөр хоорондоо харилцан хамааралгүй (мөндөр, хяруу, түймэр г.м.) эрсдэлийн төрлүүдийг нэгтгэн нэг даатгалын гэрээгээр даатгах боломжтой.

Индексжүүлсэн даатгал

Даатгалын энэ хэлбэрийг тариалангийн аж ахуй нэгж нь байгаль цаг уурын гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиоход гарсан санхүүгийн хохирлыг нөхөх зорилгоор мөн ашигладаг. Индексжүүлсэн даатгалыг энгийнээр тайлбарлавал: Талбайд учирсан бодит хохирол нь тухайн нутаг орон/ цаг агаарын индекстэй аль болох харилцан хамааралтай тохиолдолд нөхөн олговрыг олгодог.

Индексжүүлсэн даатгалыг хэрэгжүүлэхийн тулд нэн тэргүүнд цаг агаарын индексийг тогтоох хэрэгтэй. Цаг агаарын индексийг өмнө нь мэргэжлийн хүмүүс математик загварчлал гарган, нарийн тооцоолон хийдэг байсан бол өнөө үед энэхүү тооцооллыг ухаалаг утасны болон хэрэглээний

программууд ашиглан тооцох боломжтой болсон ба энэ нь цаг агаарын индексжүүлсэн даатгалыг илүү хялбарчилсан юм. Түүнчлэн хур тунадасны хэмжээ, агаарын температурын дундаж хэмжээ, температурын хэлбэлзлийн доод болон дээд заалт, нарны тусгалын нийт хугацаа зэрэг ургацад нөлөөлөх олон хүчин зүйлийг цаг агаарын индекс болгон ашиглах боломжтой. Цаг агаарын индексжүүлсэн даатгал нь индексийн босго түвшин /Strike Level/ тогтоодог ба хохирлын хэмжээг тухайн түвшинтэй харьцуулах замаар нөхөн төлбөрийн хэмжээг тооцдог. Нөхөн олговрын хэмжээг Tick-Size-p тооцоолох бөгөөд энэ нь индексийн нэгж бүрийг мөнгөн хэлбэрт оруулан тооцно гэсэн үг юм. ХБНГУ-д индексийг ихэвчлэн даатгуулагч аж ахуйн нэгжийн статистик мэдээллийг тухайн жилийн төлөвлөсөн ургацын хэмжээтэй харьцуулан тооцож гаргадаг бөгөөд ингэхдээ учирч болох эрсдэлүүдийг давхар харгалзан үздэг. (дэлгэрэнгүйг <http://www.die-wetterversicherung.de> харна уу)

Цаг агаарын индексжүүлсэн даатгалыг амжилттай хэрэгжүүлж буй нэг жишээ нь Канад улсын „Forage Rainfall Program“ юм.

Канадын AGRECORP даатгалын компани нь улирлын чанартай гангийн үед ургац алдах эрсдэлээс хамгаалах зорилгоор цаг агаарын индексжүүлсэн даатгалыг санал болгодог. Цаг агаарын индексийг сарын дундаж хур тунадасны хэмжээгээр тогтоодог бөгөөд даатгалын хугацаа нь 5, 6, 7, 8 саруудыг хамарна.

Хамгийн ойролцоо байрлах цаг уурын станцын мэдээгээр тухайн сарын хур тунадасны хэмжээ нь олон жилийн дунджаас 80%-с доош байгаа үед даатгалын тохиолдол гарлаа гэж үзнэ. Тариаланч нь даатгалын хураамж, даатгалын нөхөн олговрын хэмжээнээс хамаараад олон төрлийн гэрээний нөхцөлүүдээс сонголтоо хийх боломжтой. Тариаланч нь нэн тэргүүнд даатгуулах талбайд үнэлгээ хийлгэх ёстой бөгөөд тухайн талбайн чанар, таримлын төрөл зэргээс хамаарч үнэлгээг тогтоодог. Эцэст нь даатгалын нийт үнийг талбайн хамгийн доод үнээс их байхаар тогтооно. Даатгалын нийт үнээс хамаарч даатгалын хураамжийг хувиар тооцон тогтооно. Тухайн хувь нь даатгалын нөхөн олговрыг хэрхэн тооцоолохоос хамаарна. Даатгалын нөхөн олговрыг тооцоолоход 4 төрлийн сонголт/ загвар байдаг ба загвар тус бүр тухайн сард унах хур тунадасны хэмжээгээрээ өөр хоорондоо ялгаатай. Аль загварыг сонгосноос шалтгаалан хураамжийн хувь хэмжээ даатгалын нийт дүнгийн 3,23%-с 10,08%-тай тэнцэнэ. Канадад даатгалын хураамжийн 60 хүртэлх хувийг төрөөс санхүүжүүлж байна. Мөн АНУ-д цаг агаарын индексжүүлсэн даатгалыг бүс нутгийн ургацын даатгал хэлбэрээр хэрэгжүүлдэг байна.

Дараах хүснэгтэд уламжлалт болон индексжүүлсэн даатгалын гол ялгааг хураангуй байдлаар харууллаа.

Уламжлалт болон Индексжүүлсэн даатгалыг харьцуулах нь

Уламжлалт даатгал	Индексжүүлсэн даатгал
Даатгалын эрсдэлийг нэрлэх (Жишээ нь: Мөндөр)	Агаарын температур, хур тунадас, нарны тусгалын хугацаа зэрэг шууд бус хэмжигдэхүүнийг тооцоололд ашиглана.
Бодит, тооцох боломжтой хохирол гарсан үед даатгалын тохиолдол гэж үзнэ	Дээрх хэмжигдэхүүн өөрчлөгдөхөд тариалангийн аж ахуйн нэгжид ямар үр дагавартай, эдийн засгийн хувьд хэр их хор хохиролтойг тооцно
Даатгалын шинжээч/ үнэлэгч хохирлын түвшинг тогтооно.	Хохирлын түвшин нь гэрээнд заасан хэмжигдэхүүний түвшинг давсан үеэс эхэлнэ /тухайлбал, агаарын температур, хур тунадас, нарны тусгал/
Анхаарах: Тарималд заавал биет хохирол учирсан байх ёстой.	Анхаарах: Тарималд заавал биет хохирол учрах албагүй ч магадлал өндөртэй.

3. Тоон мэдээллийн дүн шинжилгээ

ХААДД ХК-аас санал болгож буй даатгалын бүтээгдэхүүн

ХААДД ХК нь туршилтын шугамаар “Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал” гэсэн нэрийн доор харьцангуй өндөр хамгаалалт бүхий даатгалын бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Энэхүү даатгалын бүтээгдэхүүн нь ургацын алдагдлыг нөхөх даатгалын хэлбэрээр загварчлагдсан ба дараах эрсдэлүүдээс хамгаална. Үүнд:

- Газар хөдлөлт
- Ган
- Цочир хүйтрэл
- Мөндөр
- Түймэр
- Хүчтэй салхи, шороон шуурга
- Аадар бороо, үргэлжилсэн бороо, үер
- Ургамлын өвчин, шавж, мэрэгч амьтан
- Санаатай хорлон сүйтгэх үйл ажиллагаа, гуравдагч этгээдийн буруутай үйлдэл
- Тариан талбайд мал орох

ХААДД ХК нь “Нэрлэсэн эрсдэлт улаан буудайн даатгал”-ыг анх 2 аймгийн 9 суманд туршиж эхэлсэн бол 2017 онд 4 аймгийн 8 суманд хэрэгжүүлжээ. Энэхүү даатгалын бүтээгдэхүүнийг туршсан аймаг, сумдыг газар зүйн байрлал, байгаль цаг уурын онцлог, улаан буудайн тариалалт болон тухайн нутаг оронд учирч болох эрсдэлүүдийг харгалзан сонгосон болно. Туршилтын хугацаанд нийт 5.000-10.000 га талбайг даатгана гэж төлөвлөжээ. Даатгуулсан тариаланч нь сүүлийн 5 жилийн дундаж ургацын хэмжээг тооцон түүнээс 40 эсвэл 50 хувийг өөрийн хүлээх хариуцлагын түвшин болгон сонгох боломжтой юм.

Даатгалын үнэлгээний хувьд тариаланч нь гурван янзын тарифын аль нэгийг сонгох (385.000 төгрөг, 550.000 төгрөг, 700.000 төгрөг) бөгөөд даатгалын тохиолдол бүр үнэлгээнээс тооцогдох ба даатгалын гэрээнд нөхөн олговрын дээд хэмжээг тусгаж өгдөг.


Улаан буудайн даатгалын хураамж нь даатгалын үнэлгээний 6,56%-тай тэнцэх ба даатгалын гэрээг эрт байгуулах, урт хугацаанд нөхөн төлбөр аваагүй зэрэг тохиолдлуудад хөнгөлөлт эдлэх боломжтой.

Даатгуулсан таримал/ талбай¹

Тариалангийн салбарт ямарваа нэгэн даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд эдийн засгийн ач холбогдлыг тооцоолох шаардлагатай ба нэн тэргүүнд даатгалд хамрагдах боломжит хүрээг/ талбайг үнэлэх хэрэгтэй. Энэхүү дүр зургаас даатгалын сангийн дээд хэмжээ, даатгалын хураамжийн портфолио тодорхойлох боломжтой. Мөн урт хугацаанд даатгалын эрсдэлийг тооцож, үнэлснээр түүнд тохирох хураамж болон даатгалын нөхцөл зэргийг тогтоох боломжтой.

Нэн тэргүүнд Монгол орны нийт тариалангийн талбайн хэмжээг тооцох хэрэгтэй. Нийт тариалангийн талбайг энд ойлгомжтой болгох үүднээс нийт эргэлтийн талбайн хэмжээгээр авч доорх тооцоололд ашигласан болно.

Доорх хүснэгтээр нийт эргэлтийн талбайн хэмжээг аймаг тус бүрээр харуулав.




2010-2016 оны хооронд дээрх бүх аймгуудад эргэлтийн талбайн хэмжээ өссөн үзүүлэлтэй харагдаж байна. Нийт эргэлтийн талбай нь 153.924 га-аас 266.469 га болтлоо өссөн ба 2015 онд 347.479 га-д тариалалт хийсэн нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Энэхүү 347.479 га-г онолын хувьд ирээдүйд даатгах боломжтой нийт талбай гэж тооцож болно.

2000 – 2016 оны даатгалын үнэлгээ, хураамжийг тооцоолохдоо зохиогч нь нийт эргэлтийн талбай нь тухайн жилүүдэд даатгагдсан байсан бол, дараах дүр зураг харагдах байжээ гэж таамаглал дэвшүүлэх замаар тооцоолжээ

Даатгалын бүтээгдэхүүний эдийн засгийн ач холбогдлыг тооцоход сүүлийн жилүүдэд даатгалын зах зээлийн нийт хэмжээ хэрхэн өссөн талаарх мэдээлэл чухал юм. 2010 онд даатгалын үнэлгээ 9.565.879.132 төгрөг байсан бол энэ нь 2015 онд 20.913.791.717 төгрөг болж, дээд цэгтээ хүрсэн ба 2016 оны мэдээгээр 15.634.760.296 төгрөг болсон байна.

Нийт эргэлтийн талбайн хэмжээг даатгалын үнэлгээтэй харьцуулахад хоёуланд нь адил өсөлт харагдаж байна. Сүүлийн 16 жилийн мэдээллээс харахад даатгалд хамрагдсан тариалангийн аж ахуйн нэгжүүдийн сонирхолд ямарваа нэгэн өөрчлөлт гараагүй ба доорх графикаас даатгалын үнэлгээний хэмжээ өсч байгааг хялбархан харах боломжтой юм.



Даатгалын багцын ихэнх хувийг буюу 55,88%-г Сэлэнгэ аймаг дангаараа эзэмшдэг бөгөөд энэхүү төвлөрөл нь тариалангийн даатгалын үйл ажиллагаанд эргээд эрсдэл үүсгэж байгаа тул цаашид энэ асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Үндсэн эрсдэлүүд болон цаг агаарын мэдээний дүн шинжилгээ

Монгол орон нь газар тариалан эрхлэхэд төдийлөн тохиромжгүй, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Ялангуяа тариалалтын улирал богино, хур тунадасны хэмжээ бага байдаг нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг. Жилдээ нутгийн баруун болон өмнөд хэсгээр 110-140 мм, зүүн хэсгээр 200-230 мм, нутгийн хойд хэсгээр 220-350 мм хур тунадас ордог байна. Сүүлийн жилүүдэд Монгол орны тариалангийн бүс нутгийг хамарсан гангийн тоо, давтамж өссөн бөгөөд эрсдэлийн менежментийн зүгээс авч үзэхэд ган нь эдийн засагт хамгийн их нөлөө үзүүлэх, хохирол учруулах эрсдэлийн төрөлд багтана. Хамгийн сүүлд 2017 онд тариалангийн ихэнх бүс нутгийг хамарч хур тундас багатай, зарим бүс нутгуудад огт хур тундасгүй, олон хоног үргэлжилсэн нарны хэт их халалт явагдсан нь ургацад сөргөөр нөлөөлж, эдийн засгийн хувьд томоохон

хохирол дагуулсан. Тариалангийн салбарын бусад эрсдэлүүд нь гантай харьцуулахад харьцангуй бага эдийн засгийн хохирол дагуулдаг. Монгол орны хэмжээнд цаг уурын сүлжээний нийт 318 өртөө, харуул ажиллаж байгаагаас 183 нь цаг уурын харуул ба үлдсэн 135 цаг уурын өртөө юм. Дээр дурьдсан туршилтын төслийн хүрээнд дараах хэмжилтийн цэгүүдээс цаг агаарын мэдээллийг авсан. Үүнд:

Аймаг	Сум	Хэмжилтийн арга
Сэлэнгэ	Цагааннуур	Станц
Сэлэнгэ	Ерөө	Станц
Сэлэнгэ	Орхонтуул	Станц
Булган	Хутаг-Өндөр	Станц
Төв	Жаргалант	Станц
Төв	Эрдэнэсант	Станц
Дорнод	Халхгол	Станц
Сэлэнгэ	Зүүнбүрэн	Автомат станц
Сэлэнгэ	Хушаат	Автомат станц
Дархан-Уул	Хонгор	Автомат станц

Цаг уурын өртөө нь бодит хугацааны цаг агаарын төлөв байдлыг бүрэн автоматаар тооцон мэдээлдэг учраас индексжүүлсэн даатгалд ашиглах боломжгүй юм.

Ус, цаг уур, орчны мэдээлэл нь голчлон агаарын температур болон хур тунадасны хэмжээнд дүн шинжилгээ хийхэд төвлөрдөг. Харин Герман-Монголын хамтын ажиллагааны Тогтвортой хөдөө аж ахуй төслийн өмнө нь хийсэн судалгаагаар стратегийн чухал бүтээгдэхүүн болох улаан буудай нь гангийн эрсдэлд нэрвэгдэх магадлал хамгийн өндөр байгаа нь тогтоогджээ.


Олон хоног хур тунадас орохгүй, агаарын температур хэт өндөр байх нь ган болох үндсэн шалтгаан болдог. Агаарын температур хэт өндөр байх нь тарималд халууны стресс үүсгэж, улмаар ургац алдахад хүргэдэг.

Байгаль, цаг уурын онцлогоос шалтгаалан тариалалтын нийт хугацаа нь Монгол орны хувьд 95-110 хоног үргэлжилдэг.

Агаарын температур

Улаан буудайн халуунд тэсвэрлэх чадварыг судалсан судалгаанаас харахад агаарын температур цельсийн +30 хэмд хүрэхэд ургамал чийгээ алдаж, хатаж эхэлдэг байна. 2000-2016 оны цаг уурын мэдээллээс онцлон шөнөдөө хяруу унах, хэт хүйтрэх эрсдэл хамгийн багатай байдаг 5-аас 9-р саруудын мэдээг харахад, дараах зүйлс анхаарал татлаа. Үүнд:

- 5-аас 9-р саруудын хооронд агаарын температур цельсийн +40 хэм хүрсэн тохиолдол нийт 14 удаа бүртгэгдсэн байна.
- Цаг уурын хэмжилтийн цэгүүдэд хийсэн нийт 275 хоногийн цаг агаарын хэмжилтээс харахад 5-р сард агаарын температур цельсийн + 30 хэмд хүрсэн байна.
- Цаг уурын хэмжилтийн 10 цэгт хийсэн нийт 26.234 хоногийн хэмжилтээс 5-аас 9-р саруудад нийт 3.860 хоногт агаарын температур цельсийн +30 ба түүнээс дээш хэмд хүрсэн байна. Дэлгэрэнгүйг доорх графикаас харна уу:



Тариалалтын улиралд агаарын температур хэт халсан өдрүүдийн хувийг хүснэгтээр үзүүлбэл:

Цаг агаарын хэмжилтийн цэг	2000 оноос хойш агаарын температур цельсийн +30 буюу түүнээс дээш хэмд хүрсэн нийт өдрийн тоо	Тариалалтын нийт хугацаанд хэт халсан өдрүүдийн эзлэх хувь
Эрдэнэсант	233	9,0%
Жаргалант	325	12,5%
Халхгол	410	15,8%
Хонгор	471	18,1%
Хушаат	381	14,6%
Хутаг-Өндөр	381	14,6%
Орхонтуул	485	18,6%
Цагааннуур	271	10,4%
Ерөө	445	17,1%
Зүүнбүрэн	458	17,6%

Дээрх хүснэгтээс харахад нийт тариалалтын хугацаанд агаарын температур цельсийн +30 ба түүнээс дээш хэм хүртэл халсан өдрүүдийн эзлэх хувь хамгийн багадаа 9, ихдээ 18,6 хувьтай байгаа бөгөөд дундаж нь 14,83 хувьтай гарч байна. Халалтын байршлыг нарийвчлан хэмжих үүднээс гол цэгийг /Median/ математикийн аргаар тооцвол гол цэгт 15,2 хувьтай гарч байгаа нь статистик дунджаас дээгүүр байна.

Агаарын температурыг тариалангийн индексжүүлсэн даатгалд хэмжих нэгж болгон ашиглахын давуу тал нь температур нь хур тунадастай харьцуулахад бүс нутгийн хэмжээнд харьцангуй жигд байдаг тул цөөн тооны цаг уурын станцын мэдээ хангалттай. Мөн агаарын температурын өөрчлөлт хур тунадасны хэмжээнд нөлөөлдөг ба өөрөөр хэлбэл агаарын температур өсөхөд хур тунадасны хэмжээ огцом буурдаг. Монголд цаг уурын мэдээлэл харьцангуй сайн байдагтай холбогдуулан агаарын температурыг тариалангийн индексжүүлсэн даатгалд гол хэмжих нэгж болгон ашиглах боломжтой юм.

Хур тунадас

Дээр дурдсанчлан хур тунадасны тархалт нь агаарын температуртай харьцуулахад бүс нутгийн хэмжээнд төдийгүй нэг нутаг оронд ч харилцан адилгүй байдаг. Иймд туршилтын явцад зөвхөн 10 цаг уурын хэмжилтийн цэгт бүртгэгдсэн хур тунадасны мэдээг ашигласан бөгөөд энэ нь хур тунадасыг тариалангийн индексжүүлсэн даатгалд хэмжигч нэгж болгон ашиглах боломжгүйг харуулж байна.

Монгол орны хэмжээнд цаг уурын сүлжээний нийт өртөөн дээр хур тунадасны тархалт, хэмжээний талаар олон жилийн турш хуримтлагдсан мэдээллийн сан үүссэн бол, индексжүүлсэн даатгалд хэмжих нэгж болгон ашиглах боломжтой эсэхийг судлах нь зүйтэй. Мөн хур тунадасны хэмжээ, тархалт нь гангийн эрсдэлийг тооцоолоход чухал үзүүлэлт болох юм.

Цаг уурын станцууд дээр бүртгэгдсэн 2002-2016 оны хур тунадасны хэмжээг доорх хүснэгтээр харууллаа.


Монгол орны хур тунадасны хэмжээ нь улаан буудайн үйлдвэрлэл эрхэлдэг бусад орнуудтай харьцуулахад маш бага байгааг онцлох нь зүйтэй. Хур тунадасны урт хугацааны арифметик дунджийг хэмжилтийн цэг тус бүрээр гаргахад Булган аймгийн Хутаг-Өндөр суманд хамгийн их буюу 322,44 мм хур тунадас унасан бол Дархан-Уул аймгийн Хонгор суманд хамгийн бага буюу 223,69 мм хур тунадас унасан байна.

Хэмжилтийн цэг	2000-2006 онуудын хур тунадасны нийт хэмжээ	хур тунадасны жилийн дундаж хэмжээ
Эрдэнэсант	3990,6	249,41
Жаргалант	5204,8	325,30
Халхгол	5048,5	315,53
Хонгор	3578,8	223,68
Хушаат	3582,7	223,92
Хутаг-Өндөр	5319,1	332,44
Орхонтуул	5073,9	317,12
Цагааннуур	4562,0	285,13
Ерөө	4513,9	282,12
Зүүнбүрэн	4453,1	278,32

Тариалалтын улиралд агаарын температур хэт халснаас хур тунадасны нилээдгүй хэсэг нь хөрсөнд шингэж амжилгүй ууршин алга болдог. Иймд усан гадаргын болон хөрсний гадаргын усны ууршилтын түвшинийг хэмжих нь зүйтэй. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр тариалангийн салбарын гол эх үүсвэрийн нэг болох гол мөрөн, нуур зэрэг усан сан ба хуурай гадаргын усанд ууршилт хэр явагдаж байгаад анхаарлаа хандуулах нь чухал юм. Мөн усны ууршилтад нөлөөлж байгаа хүчин зүйлсийг нарийвчлан судлах нь зүйтэй юм. Зохиогчийн зүгээс Пенманийн (1948) аргыг ашиглан ууршилтын түвшнийг тооцоолох нь тохиромжтой гэж үзэж байна. Ууршилтад нөлөөлдөг 3 гол хүчин зүйл байдаг нь: нарны тусгал, туяанаас ялгаруулж буй илч, дулаан, газрын гүнийн дулаан болон салхины хурд юм. Мөн ууршилтын түвшнийг хэмжихэд агаарын чийгшилийг хэмжинэ.

Даатгалын хураамжийн өсөлт


Хохирлын хэмжээ/ хохирлын нөхөн төлбөрийг зөв тодорхойлохын тулд даатгалын хураамжийн өсөлтийг анхаарах нь зүйтэй.



Даатгалын үнэлгээний хэмжээ өссөнтэй холбогдуулан даатгалын хураамж мөн огцом өсөх хандлагатай харагдаж байгаа бөгөөд 2015 онд хураамжийн хэмжээ хамгийн их буюу 1,5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Дээрх графикаас харахад өнгөрсөн жилүүдэд даатгуулсан талбайн нийт хэмжээ өссөнтэй холбоотойгоор даатгалын хураамжийн хэмжээ дагаад өсчээ. Даатгалын нийт хураамжийн дийлэнх хувийг Сэлэнгэ болон Төв аймаг эзлэх бөгөөд 2008 оноос Дархан болон бусад аймгуудын даатгалын хураамжийн хэмжээ мөн өссөн дүнтэй харагдаж байна.


Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ



Даатгалын нөхөн төлбөрийн өсөлт бууралтыг графикаас харахад 2002, 2005 болон 2015 онуудад гарсан нөхөн төлбөрийн хэмжээ анхаарал татаж байна. Сэлэнгэ болон Төв аймгууд даатгалын хураамжийн бүрдүүлэлтэд томоохон хувь эзэлдэг тул даатгалын нөхөн төлбөрийн эзлэх хувь хэмжээ эдгээр аймгуудын хувьд мөн өндөр байна. Харин Сэлэнгэ аймгийн хувьд 2015 онд даатгалын нөхөн төлбөр огт гараагүй нь даатгалын санд эерэг нөлөө үзүүлжээ. Энэ нь даатгалын багцад эрсдэлийг тараан байршуулах нь ямар чухал болохыг харуулж байна. Сэлэнгэ аймаг 2015 онд даатгалын нөхөн төлбөр аваагүй нь даатгалын хамтын санг бэхжүүлэх боломж олгосон бол харин тухайн бүст хохирлын түвшин өндөр гарсан жилд даатгалын санд томоохон хүндрэл учрах магадлалтай юм.

Сүүлийн 17 жилийн статистикаас харахад даатгалын нөхөн төлбөр анх тооцолсон хэмжээнээс илүү гарсан 4 тохиолдол бүртгэгджээ. (2001 онд 111% , 2002 онд 352% , 2005 онд 356%, 2015 онд 170% гарсан бол 2017 оны гангийн нөлөөгөөр нөхөн төлбөрийн хэмжээ 456% болж дээд цэгтээ хүрсэн нь урт хугацааны хохирлын хэмжээг ихэсгэхэд нөлөөлжээ)

2008-аас 2014 онуудын хооронд даатгалын хохирол гараагүй нь даатгалын хамтын санд эрсдэлийг тэнцвэржүүлэх боломж олгосон байна.



Ирээдүйд гангийн давтамж ихсэх эрсдэлтэй тул одоогийн даатгалын хураамж нь орлого, зарлагын харьцааг тэнцвэржүүлж, эдийн засгийн хувьд үр ашигтай байж чадахгүй юм.

Өгөгдсөн тоон мэдээлэлд тулгуурлан дүн шинжилгээ хийхэд, үүнийг дараах байдлаар тайлбарлах боломжтой:

2000 оноос хойш нөхөн төлбөрийн зардалд нийт 9.541.613.448,88 төгрөг зарцуулсан бол даатгалын хураамжаас төвлөрсөн орлого 14,170.871.268.97 төгрөг байсан гэж тооцвол сүүлийн 17 жилийн хохирол нь 67,29 %-тай гарч байна. Энэ нь хэрвээ үйл ажиллагааны бүх зардал, тодорхой хувийн ашиг, мөн ирээдүйд өсөх магадлалтай гангийн давтамж зэргийг эс тооцвол боломжийн харагдаж болох юм. Иймд дараагийн хэсэгт зардлын хэмжээ хэрхэн өөрчлөгдөж байгааг харууллаа.

Зардлын хувь хэмжээ

Сүүлийн хоёр жилийн зардлын мэдээлэлд үндэслэсэн дүн шинжилгээг доорх хүснэгтээр харууллаа:

	2016	2017
Underwriting-н зардал	₮ 6.796.131,00	₮ 3.741.360,00
Хохирлын үнэлгээний зардал	₮ 1.474.250,00	₮ 4.855.450,00
Хохирлын нөхөн төлбөр	₮ -	₮211.173.419,40
ХААДД ХК-ийн нийт нөхөн олговор	₮ -	₮ 35.899.481,30
Глобал Рэйний нийт нөхөн олговор	₮ -	₮168.938.735,52
Даатгалын хураамж	₮ 13.699.146,00	₮ 46.327.699,28
ХААДД ХК-ийн давхар даатгалын хураамж	₮ 2.054.871,90	₮ 7.875.708,88
Глобал Рэйний давхар даатгалын хураамж	₮ 10.959.316,80	₮ 37.062.159,42
Хохирлын харьцаа/хувь	0%	456%
Зардлын харьцаа/ хувь	60%	19%
Хохирол – зардлын харьцаа	60%	474%

2016 онд ХААДД ХК-ийн зардлын хувь хэмжээ нь 60%-д хүрсэн бөгөөд даатгалын хамтын сан нь урт хугацаандаа энэ хэмжээний зардлыг даах боломжгүй юм. Бусад орны ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компаниудын зардлын нийт хувь хэмжээ нь даатгалын хураамжийн 20-30 %-тай тэнцдэг бөгөөд зарим тохиолдлуудад түүнээс ч доогуур байдаг.

2017 онд зардал нь 19%-тай гарсан нь бусад орнуудын жишигт ойртох боломжтойг харуулж байна. Иймд ойрын ирээдүйд зардлын хувь хэмжээг 20%-иас хэтрүүлэхгүй байх зорилт тавих нь зүйтэй юм. Зарим төрлийн даатгалын системд тухайлбал, индексжүүлсэн даатгалд ган, хяруу, хур тунадасны эрсдэлийг “ажлын ширээн дээрээс” компьютерийн программ ашиглан тооцоолон гаргаж ирэх боломжтой тул, зардлыг тэг болтол бууруулах боломжтой. Энэ тохиолдолд зөвхөн цаг уурын мэдээ цуглуулахтай холбоотой зардал гарах ба үүнийг Underwriting-ийн зардалд шингээх боломжтой. Эрсдэлийн үнэлгээ хийхэд цаг уурын мэдээ цуглуулахтай холбоотой зардлууд тогтмол гардаг.

Ургацын хэмжээ

Монгол орны хөрсний бүтэц, шинж чанар, тариалалтын улирал, хур тунадасны хэмжээ зэрэг нь ургацын хэмжээ бага байхад шууд нөлөөлдөг.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны гаргасан мэдээллээр 2009-өөс 2014 онуудад нэг га-аас дунджаар 14,9 центнер үр тариа хураан авчээ.

Иймд жилд нэг га-гаас дунджаар 14-өөс 16 центнер ургац авна гэж дунд хугацаанд төлөвлөх боломжтой. Мэдээллийн бусад эх сурвалжуудаас харахад нэг га-гаас 16,7 центнер улаан буудайн ургац авдаг гэсэн мэдээлэл мөн байна. Нэг га-гаас авч буй ургацын дундаж хэмжээг даатгалын үнэлгээг тооцоолоход ашигладаг.

Техник технологийн хөгжил дэвшил, селекцийн ажилд гарч буй ололт, амжилт зэргээс хамаарч тариалангийн даатгалд ургацын хүлээгдэж буй түвшинг урт хугацаандаа харьцангуй өндөр тогтоох нь зүйтэй.

Ургацын хэмжээг сүүлийн 15 жилээр авч үзэхэд 2003 онд га-аас дөнгөж 8 центнер ургац хурааж байсан бол өнгөрсөн хугацаанд тус үзүүлэлт нь хоёр дахин өссөн байна.



Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны гаргасан мэдээллийг ашиглан улсын хэмжээнд хураасан буудайн ургацын өсөлт бууралтыг доорх графикаас харна уу:



2009-өөс 2014 онуудын ургацын дундаж хэмжээ 429.667 тоннд хүрсэн байна. Талбайн хэмжээнд өөрчлөлт орохгүй гэж үзвэл дээрх дүнг даатгалын тооцоо, төлөвлөлтөд улсын хэмжээнд хүлээгдэж буй ургацын дүн болгож ашиглах боломжтой.

Дүгнэлт

Тариалангийн даатгалын системийг шинээр нэвтрүүлэхээр зорьж байгаа тохиолдолд Монгол Улсад хамгийн тохиромжтой хувилбар нь индексжүүлсэн даатгал юм. Тариалангийн индексжүүлсэн даатгалд үйл ажиллагааны болон хохирлын үнэлгээний зардал харьцангуй бага байдаг тул энэ нь даатгалын хураамжийг багасгахад эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Тухайлбал, улаан буудайнд даатгалын хураамжийг тогтоохдоо гангийн эрдэл үүсэх магадлалаас нь хамааран даатгуулсан эрсдэлийн 3-12 %-иар (ROL - Rate on line) тооцох нь зүйтэй. Зохиогчийн зүгээс ХААДД ХК гадны давхар даатгагчтай хийсэн даатгалын гэрээний заалтыг ямарваа нэгэн байдлаар зөрчөөгүй тохиолдолд тодорхой үнийн тооцоолол хийж, санал болгох боломжтой юм.

Тариалангийн салбарт нь улаан буудайн үйлдвэрлэл зонхилох байр суурийг эзэлдэг улс орнуудад тариалангийн индексжүүлсэн даатгал нь ихэвчлэн Төрийн татаас дэмжлэгээр хэрэгжсэн байдаг.

ХААДД ХК-аас санал болгож буй тариалангийн даатгал нь олон төрлийн эрсдэлийг зэрэг даатгасан, хэт өргөн хүрээг хамран хийгдсэн нь даатгалын актуар тооцоог алдаатай хийх эрсдэлийг нэмэгдүүлж, улмаар даатгалын хураамж өсөх гол нөхцөл болж байна. Иймд цаашид уламжлалт эсвэл индексжүүлсэн даатгалын алийг нь сонгохоос үл хамааран даатгалын

хамгааллын хамрах хүрээг хязгаарлах шаардлагатай. Стратегийн гол нэрийн бүтээгдэхүүн болох буудайн ургацыг гангийн эрсдэлээс хамгаалах нь тариалан/ даатгалын салбарт тулгараад байгаа хамгийн чухал сорилт гэж зохиогчийн зүгээс харж байна.

Тариалангийн даатгалын хувьд эцсийн зорилго нь аль болох их талбайг даатгах замаар даатгалын хураамжийг бүрдүүлж, даатгалын хамтын санг бэхжүүлэх явдал юм. Статистикийн хувьд ч том тоонд актуар тооцоолол хийх нь тооцооллын алдаа гарах эрсдэлийг багасгаж, үр ашигтай давхар даатгалын стратеги боловсруулах боломж олгодог. Дунд хугацаандаа 350.000 га талбайг даатгалд хамруулах боломжтой гэж зохиогчийн зүгээс харж байна.

Өнөөгийн байдлаар Сэлэнгэ, Төв аймгуудын даатгалын багцад эзлэх хувь хэмжээ хэт өндөр байгаа тул эрсдэлийг тараан байршуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл бусад аймгуудын тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн талбайг даатгалд түлхүү хамруулах замаар тэдний даатгалын багцад эзлэх хувь хэмжээг ихэсгэх нь зүйтэй.

Цаг уурын мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнээс харахад улаан буудайн ургацад нөлөөлөх гол эрсдэл нь хуурайшилт, халалт юм. Тариалалтын үед нийт 15,2%-д нь агаарын температур цельсийн +30 буюу түүнээс дээш хэмд хүрч байгаа нь ургамлын өсөлт зогсож, халууны стресст орж улмаар ургац алдах нөхцөлийг бий болгож байна. Мөн хур тунадасны хэмжээ хангалттай биш тул усан гадаргын болон хөрсний гадаргын усны ууршилтын түвшинг цаашид эрсдэлийн шинжилгээнд харгалзан үзэх нь чухал юм. Хур тунадасны хэмжээ бага байх тусам ууршилтаас үүсэх сөрөг нөлөө ихтэй байдаг.

ХААДД ХК-аас санал болгож буй даатгалын бүтээгдэхүүн нь олон төрлийн эрсдэлийг зэрэг даатгасан тул, даатгалын хураамжийн өнөөгийн хувь хэмжээ нь ирээдүйд үүсэх хохирлыг нөхөхөд хүрэлцэхгүй. Даатгалын хураамжийг нэмэгдүүлэх нь даатгуулагчийг санхүүгийн улам хүнд байдалд оруулах тул даатгалын хамгааллын хамрах хүрээг хязгаарлаж, зөвхөн гол эрсдэл дээр төвлөрөх замаар зардлыг бууруулах хэрэгтэй. Тариалангийн даатгалын үйл ажиллагаа нь даатгалын хураамжийн хэмжээнээс шууд хамаардаг тул даатгалын компанийн менежмент нь үйл ажиллагааг өндөр үр ашигтай байлгаж, зардлыг хамгийн бага түвшинд барихыг зоридог. Иймд зардлын хувь хэмжээг хамгийн ихдээ даатгалын хураамжийн 20%-тай тэнцэхүүлэхийг зорих хэрэгтэй.

Өгөгдсөн тоон мэдээлэл дээр үндэслэн тариалангийн аж ахуйн нэгжийн га-аас авах дундаж ургацыг 15 центнер, улсын хэмжээний ургацын дунджийг

430.000 тонн гэж тооцоолох боломжтой. Мөн тариаланчтай даатгалын гэрээг байгуулахдаа даатгуулсан ургацын тонн бүрийг зах зээлийн үнийн жишгээр тооцоолох нь зүйтэй.

Байгаль цаг уурын хатуу ширүүн уур амьсгалтай, гангийн эрсдэлд өртөх магадлал өндөртэй Монгол орны хувьд хамгийн тохиромжтой даатгалын хувилбар нь тариалангийн индексжүүлсэн даатгал юм.

4. Төрийн дэмжлэг - боломж ба хязгаар

Тариалангийн салбарт гангийн эрсдэл тохиох магадлал өндөр, тариалангийн даатгалын хамгаалалт нь хэтэрхий өргөн хүрээг хамарсан зэргээс харахад Төрийн татаас, урамшуулал зайлшгүй хэрэгцээтэй байна.

Иймд Монголын талд Төрийн татаас, урамшууллын зөв арга механизм нэвтрүүлэх тал дээр зөвлөгөө авах хэрэгцээ шаардлага байна.

Төрийн татаас урамшууллын механизм нь бусад улс орнуудын хувьд хэрхэн ажилладаг болохыг харьцуулах зорилгоор Баруун Европын зарим улс орнуудын системийг судлан үзлээ.


Нэн тэргүүний асуудал нь онцгой байдлын үед тариалангийн аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг Төрийн дэмжлэг туслалцаа байдаг эсэхийг тодруулах явдал юм. Хэрэв Төрөөс тариаланчдын төлөх даатгалын хураамжийн тодорхой хувьд татаас олгодог бол онцгой байдлын үед дахин дэмжлэг, урамшуулал олгох ёсгүй. Төрөөс онцгой байдлын үед дэмжлэг үзүүлсэнээр тариаланчдыг даатгалд хамрагдах хүсэл/ мотивацгүй болгох аюултай. Харамсалтай нь ихэнх тохиолдолд энэ асуудлыг газар тариалангийн даатгалын хэлэлцүүлэгт хангалттай тусгадаггүй. Преттенхалерийн дараах хүснэгтэд гадны улс орнуудын тариалангийн даатгал дахь Төрийн татаас урамшууллын тогтолцоог харьцуулжээ.

Тариалангийн даатгал дахь Төрийн татаас, урамшууллын тогтолцоо:

	Даатгалын хамрах хүрээ	Даатгалын хураамжид үзүүлэх татаас	Онцгой байдлын үед үзүүлэх дэмжлэг/ тусламж	Оролцооны хувь	Давхар даатгал
Герман	бүгд	байхгүй	зөвхөн даатгах боломжгүй эрсдэлүүдэд	мөндөрт ойролцоогоор 35%/ олон эрсдэлт даатгалд <1%	хувийн
Франц	мөндөр/ даатгалын тусгай гэрээгээр зохицуулна	байхгүй	байгалийн гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиоход /ган, газар хөдлөлт, үер г.м./	мэдээлэл байхгүй	хувийн
Грек	Бүгд	50%	мэдээлэл байхгүй	мэдээлэл байхгүй	мэдээлэл байхгүй
Итали	мөндөр, хяруу, ган	мөндөрт 50%, олон эрсдэлт даатгалд 80%	зөвхөн даатгах боломжгүй эрсдэлүүдэд	мэдээлэл байхгүй	хувийн
Канад	бүгд	50%	даатгалын хамгаалалтгүй онцгой хохирлын тохиолдлууд	50%	улсын даатгал байж болно
Люксен-бург	бүгд	50% хүртэлх	мэдээлэл байхгүй	10%	мэдээлэл байхгүй
Австри	Бүгд	мөндөр болон хярууны даатгалын 50%	зөвхөн даатгах боломжгүй эрсдэлүүдэд (хөрсний гулсалт, цас дарах г.м.)	мөндөрт 78%, олон эрсдэлт даатгалд 56%	хувийн
Испани	Бүгд	55%	онцгой хохирлын тохиолдлууд	ойролцоогоор 42%	ихэвчлэн улсын
АНУ	бүгд	35-аас 100%	даатгалын хамгаалалтгүй онцгой хохирлын тохиолдлууд	80%	улсын даатгал байж болно

Энэхүү судалгааг хийхээс өмнө зохиогч миний бие өөрийн боловсруулсан Төрийн татаасын нэг боломжит хувилбарыг олон нийтэд танилцуулсан.

Миний зүгээс санал болгож буй хувилбар нь Төрөөс даатгалын хураамжид шууд татаас үзүүлэхийн оронд “Гамшгийн сан” байгуулах явдал юм. Ердийн тохиолдолд гамшгийн сан нь даатгах боломжгүй томоохон эрсдэл учирсан нөхцөлд тариаланчийн мэдээлэл, баримтад үндэслэн хохирлын тодорхой хэсгийг барагдуулах зорилготой байдаг. Харин зохиогчийн зүгээс санал болгож буй гамшгийн сан нь хохирлын хэлбэлзлийг тэнцвэржүүлэх зорилготой байх ба томоохон хохирол гарсан жилүүдэд даатгалын компаниудад тус сангаас дэмжлэг үзүүлэх ба хохирлын хэмжээ хэвийн гарсан жилүүдэд тус санд төвлөрсөн хөрөнгөнөөс тариаланчдад бага хүүтэй зээл олгож, салбарын хөрөнгө оруулалтыг дэмжих боломжтой. Өөрөөр хэлбэл тус сан нь нэг төрлийн Хөдөө аж ахуйн хөгжлийн банк хэлбэрээр үйл ажиллагаа явуулах боломжтой юм.



5.Боломжит хувилбаруудын шинжилгээ

Энэхүү хэсэгт есөн жилийн хугацаанд даатгалын хоёр тооцооллын арга ашиглан тооцсон хувилбаруудыг харьцуулах ба тооцооллын хугацааг 3-н шатанд хувааж авч үзэх юм.

1-р хувилбарын хүрээнд ургацын хэмжээг тогтмол өсөлттэй гэж таамаглан тус бүр га газраас 15,0; 16,7; 20,0 центнер ургац хураахаар, даатгагдсан талбайн хэмжээ мөн адил 25.000; 45.000; 50.000 га хүртэл өсөх үзүүлэлттэй байхаар, нэг центнер буудайн үнийг өнөөдрийн зах зээлийн үнээр буюу ойролцоогоор 15,50 евро (1 Евро = 2.909 төгрөг)-той тэнцүү байхаар тооцож даатгалын хураамжийн нөлөөллийг дэлгэрэнгүй харуулахын тулд хураамжийн хувийг даатгалын эрсдэлийг цагийн интервал тус бүр 5%; 8%; 10%-тай тэнцүү байхаар загварчлах нь бодит зах зээлийг баримжаалан тогтоосон хэмжээс бөгөөд даатгалын параметруудыг зөв загварчилсан нөхцөлд бодит байдлыг тооцоолох нөхцөл бүрдэнэ. Тус хувилбарт даатгалын компанийн ашигт ажиллагааны зорилтыг маш бага хувиар буюу даатгалын хураамжийн 1-1,2 хувиар тооцсон бол даатгалын компанийн үйл явц сайжирснаар үйл ажиллагааны зардлын хувь 20-с 18 түүнээс 17,5 хувь болж буурах юм. Энэхүү хувилбарын санаа нь хэрэв даатгалын бүх жилүүдэд зардлын харьцаа өмнөх жилийн тооцоололтой адилаар 67,29 хувь хүрнэ гэвэл эхний жилийн дараагаас л эрсдэлийг цаг хугацааны туршид тараах зохицуулалт алдагдаж энэ нь цаашлаад зохиолчийн дурдсан алдагдлын хэлбэлзлийг тэнцвэржүүлэх сангаас дэмжлэг авахаас өөр аргагүй нөхцөлд хүргэх юм. Энэхүү нөхцөл байдал 4-9-р жилд даатгалын зардлын хувь ихээхэн нэмэгдэж 79 хувьд хүрсэн тохиолдолд мөн тулгарах юм. Хэрэв даатгагдсан бүх талбайд бүрэн хохирол үүсэж даатгагч төрийн татаасны тусламжтай үйл ажиллагаагаа явуулах боломжтой болсон үед нийт төрийн татаасны дүн даатгалын хураамжаас хамааран 15,5-16,2 тэрбум төгрөг болно. Энэхүү дүн нь улсын эрсдэлийн зардлын хамгийн дээд зардлын хэмжээ болох ба даатгалын хураамж даатгалын хохирлын түвшингээс давсан үед жил бүрээр багасах боломжтой.

2-р хувилбар 1-р хувилбартай аргачлалын хувьд адил боловч даатгалд нөлөөлөх хүчин зүйлсийн өөрчлөлтийг илүү хүчтэй тусгаж өгөх үүднээс дундаж орлогын хэмжээг цагийн интервал тус бүрээр га газраас 15, 20 болон 25 центнер хураахаар тооцоолж нийт даатгалын тариан талбайн хэмжээг мөн 25, 50, 75 мянган га болгон өсгөх ба ургацын үнийг адилаар тооцоолох юм. Мөн үйл ажиллагааны чадварыг өмнөх хувилбараас илүү

сайжруулж түүний зардлын хувийг 20, 17,5 түүнээс 16 хувь болгон бууруулан тооцоолно. Ийм нөхцөлд хувь нийлүүлэгчийн сонирхол ихсэж орлогын хүлээгдэх түвшин 1-с 2 хувь мөн түүнчлэн сүүлийн 7-9 дүгээр жилүүдэд 5 % болон өсөх боломжтой. Даатгалын эрсдэлийн сан зардлын хувь хэмжээ урт хугацаанд тогтмол 67,29 хувьтай гарсан тохиолдолд жил бүр эерэг утгатай гарах бөгөөд уг хөрөнгийг төрийн дэмжлэггүй хохирлын зардлыг нөхөх чадвартай болох ба ирээдүйн эрсдэлийн тохиолдлуудад зориулан ашиглах сан бүрдүүлснээр бүрэн хохирлын түвшинд ч төрийн дэмжлэггүй нөхөн олговрын зардлыг төлөх чадвартай болох юм. Урт хугацааны хохирлын хувь 79 хувийг давахад түүний сүүлийн 7-9-дэх жилийн орлогын хүлээгдэж буй 5%-ийн өсөлтөд үзүүлэх сөрөг нөлөө тодорхой харагдах бөгөөд энэ нь даатгалын эрсдэлийг тэнцүүлэх зориулалттай санд нэмэгдэл орох боломжгүй болгох юм.

Зохиогчийн зүгээс дээрх тооцоолол нь төрийн татаасын хэмжээг даатгалын зарим нөхцөлд маш хялбаршуулсан аргаар тодруулж өгөх зорилгоор хийгдсэн ба даатгалын эрсдэлийн хохирлын хүлээгдэх түвшин эсвэл эрсдэл тохиолдох магадлалын шинжилгээ биш юм. Эрсдэлийг тоо хэмжээгээр эсвэл цаг хугацаанд тэнцүүлэн тараах механизмын математик тооцооллыг дээрх хялбар аргачлалаар тооцох боломжгүй. Түүнчлэн даатгалын эрсдэлд тохирсон хураамжийн хэмжээг даатгалын тооцооллын мэргэжилтэн буюу актуарч нар хийж гүйцэтгэх ёстой бөгөөд “Хөдөө аж ахуйн давхар даатгал”ХК-ийн хувьд мөн актуар тооцооллыг даатгалын үйл ажиллагаандаа ашиглах шаардлагатай. Мөн дээрх хоёр хувилбарт давхар даатгалыг харгалзан үзээгүй боловч даатгалын компани давхар даатгалд хамрагдаж хураамж төлснөөр тэдний үйл ажиллагааны зардал нэмэгдэх боловч улс орныг хамарсан томоохон хохирлын тохиолдол гарах үед хохирлын нөхөн төлбөрийг бүрэн олгох боломжтой болно.

Хувилбар 1	1-3 жил	4-6 жил	7-9 жил
Төлөвлөж буй буудайн ургац, цн/га	15.00	16.70	20.00
Тариалах талбай, га	25000	45000	50000
Үнэ, цн/га	45,089.50₮	45,089.50₮	45,089.50₮
Даатгалын үнэлгээ	16,908,562,500.00₮	33,884,759,250.00₮	45,089,500,000.00₮
5%-иар даатгуулсан эрсдэлийн даатгалын хураамж	845,428,125.00₮	1,694,237,962.50₮	2,254,475,000.00₮
8%-иар даатгуулсан эрсдэлийн даатгалын хураамж	1,352,685,000.00₮	2,710,780,740.00₮	3,607,160,000.00₮
10%-иар даатгуулсан эрсдэлийн даатгалын хураамж	1,690,856,250.00₮	3,388,475,925.00₮	4,508,950,000.00₮
ААН-ийн үйл ажиллагааны зардлын хувь	20.00%	18.00%	17.50%
ААН-ийн 5% -ийн даатгуулсан эрсдэлийн ү/а-ны зардал	169,085,625.00₮	304,962,833.25₮	394,533,125.00₮
ААН-ийн 8%-ийн даатгуулсан эрсдэлийн ү/а-ны зардал	270,537,000.00₮	487,940,533.20₮	631,253,000.00₮
ААН-ийн 10%-ийн даатгуулсан эрсдэлийн ү/а-ны зардал	338,171,250.00₮	609,925,666.50₮	789,066,250.00₮
Даатгалын компанийн хураамжаас олж буй ашигт ажиллагаа %	1.0%	1.1%	1.2%
5 %-иар даатгасан эрсдлийн хураамжийн ашиг	8,454,281.25₮	18,636,617.59₮	27,053,700.00₮
8%-иар даатгасан эрсдлийн хураамжийн ашиг	13,526,850.00₮	29,818,588.14₮	43,285,920.00₮
10%-иар даатгасан эрсдлийн хураамжийн ашиг	16,908,562.50₮	37,273,235.18₮	54,107,400.00₮
Үндсэн хөрөнгө, хохирол гарсан тохиолдолд эрсдэл хариуцах чадвар			
Эрсдэл хариуцах чадвар 5%	667,888,218.75₮	1,370,638,511.66₮	1,832,888,175.00₮
Эрсдэл хариуцах чадвар 8%	1,068,621,150.00₮	2,193,021,618.66₮	2,932,621,080.00₮
Эрсдэл хариуцах чадвар 10%	1,335,776,437.50₮	2,741,277,023.33₮	3,665,776,350.00₮
Хохирлын хэмжээ 67.29%-иас давсан тохиолдолд улсын төсвөөс олгох татаас			
5%-ийн даатгалд улсаас олгох татаас	- 98,999,633.44₮	- 230,585,786.70₮	- 315,851,947.50₮
8%-ийн даатгалд улсаас олгох татаас	- 158,399,413.50₮	- 368,937,258.71₮	- 505,363,116.00₮
10%-ийн даатгалд улсаас олгох татаас	- 197,999,266.88₮	- 461,171,573.39₮	- 631,703,895.00₮
Хохирлын хэмжээ 79%-иас давсан тохиолдолд улсын төсвөөс олгох татаас			
5%-ийн даатгалд улсаас олгох татаас	-	- 32,190,521.29₮	- 51,852,925.00₮
8%-ийн даатгалд улсаас олгох татаас	-	- 51,504,834.06₮	- 82,964,680.00₮
10%-ийн даатгалд улсаас олгох татаас	-	- 64,381,042.57₮	- 103,705,850.00₮
Улс орныг хамарсан гамшгийн үед буюу хохирлын хэмжээ 100%-д хүрсэн тохиолдолд улсын төсвөөс эхний жилд олгох татаас			
5%-ийн даатгалд улсаас олгох татаас	16,240,674,281.25₮		
8%-ийн даатгалд улсаас олгох татаас	15,839,941,350.00₮		
10%-ийн даатгалд улсаас олгох татаас	15,572,786,062.50₮		

Хувилбар 2	1-3 жил	4-6 жил	7-9 жил
Төлөвлөж буй буудайн ургац, цн/га	15.00	20.00	25.00
Тариалах талбай, га	25000	50000	75000
Үнэ, цн/га	45,089.50₮	45,089.50₮	45,089.50₮
Даатгалын үнэлгээ	16,908,562,500.00₮	45,089,500,000.00₮	84,542,812,500.00₮
5%-иар даатгуулсан эрсдэлийн даатгалын хураамж	845,428,125.00₮	2,254,475,000.00₮	4,227,140,625.00₮
8%-иар даатгуулсан эрсдэлийн даатгалын хураамж	1,352,685,000.00₮	3,607,160,000.00₮	6,763,425,000.00₮
10%-иар даатгуулсан эрсдэлийн даатгалын хураамж	1,690,856,250.00₮	4,508,950,000.00₮	8,454,281,250.00₮
ААН-ийн үйл ажиллагааны зардлын хувь	20.00%	17.50%	16.00%
ААН-ийн 5% -ийн даатгуулсан эрсдэлийн ү/а-ны зардал	169,085,625.00₮	394,533,125.00₮	676,342,500.00₮
ААН-ийн 8%-ийн даатгуулсан эрсдэлийн ү/а-ны зардал	270,537,000.00₮	631,253,000.00₮	1,082,148,000.00₮
ААН-ийн 10%-ийн даатгуулсан эрсдэлийн ү/а-ны зардал	338,171,250.00₮	789,066,250.00₮	1,352,685,000.00₮
Даатгалын компанийн хураамжаас олж буй ашигт ажиллагаа %	1.0%	2.5%	5.0%
5 %-иар даатгасан эрсдлийн хураамжийн ашиг	8,454,281.25₮	56,361,875.00₮	211,357,031.25₮
8%-иар даатгасан эрсдлийн хураамжийн ашиг	13,526,850.00₮	90,179,000.00₮	338,171,250.00₮
10%-иар даатгасан эрсдлийн хураамжийн ашиг	16,908,562.50₮	112,723,750.00₮	422,714,062.50₮
Үндсэн хөрөнгө, хохирол гарсан тохиолдолд эрсдэл хариуцах чадвар			
Эрсдэл хариуцах чадвар 5%	667,888,218.75₮	1,803,580,000.00₮	3,339,441,093.75₮
Эрсдэл хариуцах чадвар 8%	1,068,621,150.00₮	2,885,728,000.00₮	5,343,105,750.000₮
Эрсдэл хариуцах чадвар 10%	1,335,776,437.50₮	3,607,160,000.00₮	6,678,882,187.500₮
Хохирлын хэмжээ 67.29%-иас давсан тохиолдолд улсын төсвөөс олгох татаас			
5%-ийн даатгалд улсаас олгох татаас	- 98,999,633.44₮	- 286,543,772.50₮	- 494,998,167.19₮
8%-ийн даатгалд улсаас олгох татаас	- 158,399,413.50₮	- 458,470,036.00₮	- 791,997,067.50₮
10%-ийн даатгалд улсаас олгох татаас	- 197,999,266.88₮	- 573,087,545.00₮	- 989,996,334.38₮
Хохирлын хэмжээ 79%-иас давсан тохиолдолд улсын төсвөөс олгох татаас			
5%-ийн даатгалд улсаас олгох татаас	-	- 22,544,750.00₮	-
8%-ийн даатгалд улсаас олгох татаас	-	- 36,071,600.00₮	-
10%-ийн даатгалд улсаас олгох татаас	-	- 46,089,500.00₮	-
Улс орныг хамарсан гамшигийн үед буюу хохирлын хэмжээ 100%-д хүрсэн тохиолдолд улсын төсвөөс эхний жилд олгох татаас			
5%-ийн даатгалд улсаас олгох татаас	16,240,674,281.25₮		
8%-ийн даатгалд улсаас олгох татаас	15,839,941,350.00₮		
10%-ийн даатгалд улсаас олгох татаас	15,572,786,062.50₮		

6. Судалгааны тайлангийн урьдчилсан хэлэлцүүлгээс оруулсан нэмэлтүүд

Тариалангийн даатгалыг хэрэгжүүлэх боломжийн судалгааны тайланг урьдчилсан байдлаар хэлэлцүүлэхэд монголын төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгтэй холбоотой зарим нэг асуудлыг илүү тодотгох хүсэлт гаргасны дагуу зохиогчийн зүгээс энэхүү нэмэлт хэсгийг оруулахаар шийдсэн болно. Орчуулгын ажлын хөнгөвчлөх зорилгоор энэхүү тайлбарыг сүүлд нэмж оруулж, эхний бүлгүүдэд өөрчлөлт оруулаагүй гэдгийг энд дурдах нь зүйтэй.

Олон улсын жишгээс үзэхэд, төрөөс тариаланчдын даатгалын хураамжид шууд татаас олгох нь төдийлөн оновчтой шийдэл биш гэдгийг өмнө дурдсан. Олон улсын жишиг гэдэгт Монгол улсаас бусад орны жишээг авч үзсэн бөгөөд уг судалгаанд монголын тариалангийн даатгалын зах зээл дэх тариаланчдын хүлээлт, тэдний идэвхижилтийг тусгаагүй болно. Судалгааны тайлангийн төслийг ХААДД ХК-ийн төлөөлөгчдөд танилцуулсны дараа дэлгэрэнгүй хэлэлцүүлэг өрнөсөн. Уг хэлэлцүүлгийн дүнд монголын тариаланчид буюу тариалангийн даатгалын нийт зах зээлийн онцлогийг нарийвчлан судалсан нөхцөлд туршилтаар судлагдсан талбайн, түүнчлэн улсын хэмжээнд тариалангийн даатгалын тогтолцоог бий болгох, түүний тогтвортой байдлыг хангахад төрөөс санхүүгийн дэмжлэг олгох нь боломжит хэлбэр гэдэгт санал нэгдсэн. Монголын даатгалын зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлсноор уг даатгалтай холбоотой сөрөг сэтгэгдэл үүсэхгүй байх, гол нь монголын газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж, хамгаалах юм. Хэрэв богино хугацаанд энэхүү даатгалын тогтолцоог бий болгож, дийлэнх тариаланчдыг хамруулж чадвал энэ нь бидний нэн тэргүүнд хийх ажил бөгөөд аливаа эрсдэлийн учруулах хохирлыг даван туулж, түүний хүчийг сарниулах чухал ач холбогдолтой. Түүнчлэн давхар даатгалын үйл ажиллагаанд сайнаар нөлөөлнө.

Гэхдээ даатгалын хураамжид шууд татаас олгохын сул талыг тооцох хэрэгтэй бөгөөд холбогдох талуудын ашиг сонирхлыг хянах, удирдах хяналт-удирдлагын тогтолцоог зөв бүрдүүлэх шаардлагатай.

7.Эх сурвалж:

- Keller, J. (2010): Ernteversicherungen als Risikomanagement-instrument, Eine Analyse von Versicherungstypen und Tarifierungsmodellen, Dissertation, 2010.
 - Mahler, S. (2016): Subvention von Ernteversicherungen in Europa im Fokus agrarpolitischer Veränderungsprozesse, internes Unternehmenspapier gvf Versicherungsmakler AG, nicht veröffentlicht.
 - Mahler, S., Ritterhaus, D., Zschiesche, L. et al., DLG e.V. (Hrsg.) (2018): Mehrgefahrenversicherungen in der Landwirtschaft, DLG-Merkblatt 434.
 - Prettenthaler, F., Strametz, S., Töglhofer, C. et al (2006): Anpassungsstrategien gegen Trockenheit – Bewertung ökonomischfinanzieller versus technischer Ansätze des Risikomanagements.
-